



[Handwritten signature]
[Handwritten signature]

Г.БУДРАГЧАА

Б.БАДМАА



**Ажилчдын хоолыг буффет
үйлчилгээгээр шинэчлэн зохион
байгуулах, цаашид хариуцан ажиллах
тендерийн баримт бичиг**

Боловсруулсан:

Ажлын хэсэг:

Нэг. ТЕНДЕРИЙН УРИЛГА

2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Тендерийн нэр: **“Ажилчдын хоолыг буффет үйлчилгээгээр шинэчлэн зохион байгуулах, үйл ажиллагааг гэрээгээр хариуцан ажиллах”**

Тендерийн дугаар: **ЗХНА/20190101**

“Мах Импэкс” ХК нь тендер сонирхогчдоос “Ажилчдын хоолыг буффет үйлчилгээ болгон шинэчлэх, тухайн үйлчилгээнд зориулсан хоолны меню зохиох”, зохиосон меню-ний үнийн саналыг ирүүлэх, ирүүлсэн үнээр үйлчилгээ үзүүлэн цаашид хамтран ажиллахыг урьж байна.

Үнийн саналыг 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минут-с өмнө Монгол Улс, Улаанбаатар хот, СХД, 4-р хороо, “Мах Импэкс” ХК-ийн байранд **ХААХ**, хаягаар ирүүлнэ.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим систем болон бусад сувгийг ашиглан зарлагдаж байгаа тул www.makhimpex.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Мөн шаардлагатай мэдээллийг 9811-3875, 9824-5555 дугаараас авах боломжтой.

Тендерийг 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 15 цаг 30 минутад нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан “Мах импэкс” ХК-ийн хурлын зааланд нээнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Тендерт оролцогч ба эрх бүхий үйлчилгээ

1.1. Тендерт оролцогч нь ресторан хоолны газрын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллага болон хувь хүн байж болох ба Тендер зарлагч байгууллагын ажилчдын хоолыг уламжлалт порцноос буффет сонголттой болгох /меню/-г 2-3 долоо хоногийн давтамжтайгаар, олон нэр төрлөөр төрөлжүүлэн зохиох ба түүний үнийн саналыг меню зохиох жишиг хүснэгтэд заасан дүнгээс хэтрүүлэхгүй байх. Цаашид зохиосон меню дээр үйл ажиллагааг хариуцан хамтран ажиллах, нийт ажилчдад чанартай хоолоор тогтвортой үйлчлэх

2. Тендерийн иж бүрдэл

2.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

а. Буффет хоолны Меню, үнийн санал,

б. Чадварын мэдээлэл /туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бусад баримт бичиг/

в. Шаардлагатай тусгай зөвшөөрөл

г. Үнийн саналыг маягын дагуу ирүүлэх

д. Гэрээг удирдах болон технологийн голлох боловсон хүчний чадвар, туршлага, төлөвлөлтийн талаарх мэдээлэл: Тухайн хоолны газрын үйл ажиллагааг чанарын доголдолгүй, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг нотлох баримт бичгийг баталгаажуулан ирүүлнэ.

3. Тогтмол үнэ

3.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

4. Арилжааны нөхцөлүүд

4.1. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

5. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

5.1. Захиалагч меню-ний чанар, төрөлжилт болон түүний үнийн саналыг харьцуулж үнэлнэ.

**6. Үнийн саналын хүчинтэй
Хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**7. Гэрээ байгуулах эрх
Олгох тухай мэдэгдэл**

7.1. Захиалагч нь шалгарсан тендер оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажил үйлчилгээнд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг /түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт/ тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. МЕНЮ ЗОХИОХ ЖИШИГ ХҮСНЭГТ

Бид хамтран ажиллах тал дээр бүх хэлбэрээр дэмжлэг үзүүлэх ба тендерт шалгарсан хувь, хүн байгууллагын зорилго зөвхөн амт, чанартай бүтээгдэхүүнээр ажилчдыг хооллоход чиглэгдэнэ.

1. Тоног төхөөрөмжөөр бүрэн хангахаас гадна тоног төхөөрөмж болон заалны түрээсийг 0 төгрөгөөр гэрээний хугацаанд тооцох,
2. Өдөр тутам тогтмол хамгийн багадаа 300-450 хүн хоол худалдан авах

Хүснэгт-/меню зохиох жишээг үзүүлэв/

Гараг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Үнэ	-төг						
1-р хувилбар	<ul style="list-style-type: none"> - Шницель - Шаржигнуур тахиа - Алаг махан хуурга /хачир-амталсан будаа, байцаа, өндөгний салат/ - Зутан шөл - Сүүтэй цай - Жүржийн ус 	<ul style="list-style-type: none"> - Хуушуур - Халуун ногоотой гахай - 5 цулын бууз - Лууван, навчны салат - Будаатай шөл - Үзэмний шүүс - Бор цай 	<ul style="list-style-type: none"> - Соустай хонины хавирга - Халуун ногоотой мах - Өндөгний зраз /хачир-жигнэсэн гурил, амталсан төмс, байцааны салат/ - Таван цулын шөл - Бор цай - Жүржийн ус 	<ul style="list-style-type: none"> - Цуйван - Шарсан төмстэй хуурга - Плов - Гүзээний хуурга - Борц - Сүүтэй цай - Алимтай ус 	<ul style="list-style-type: none"> - Үхрийн хавирга - Шницель - Өндөгтэй бифштекс /хачир-будаа, чипс төмс, шинэ ногоо/ - Пяртан шөл - Сүүтэй цай - Жүржийн ус 	<ul style="list-style-type: none"> - Өндөгтэй хуурга - Чинжүүтэй хуурга - Будаатай хуурга /хачир-бин, будаа/ - Махтай хийцтэй цай - Жимсний шүүс - Жүржийн ус 	<ul style="list-style-type: none"> - Бууз /хачир-алаг салат/ - Соустай хавирга - Ногоотой шөл - Сүүтэй цай - Алимтай ус
2-р хувилбар	-	-	-	-	-	-	-

Дөрөв. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

“Мах Импэкс” ХК-ийн Гүйцэтгэх захирал танаа

1. Бид /тендерт оролцогчийн нэр/, /гэрээний нэр ба дугаар/-ыг /тендерийн үнийг тоогоор болон үсгээр/ төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Ажилчдын хоолны санал болгож буй буфшет меню нь тендерийн шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Меню нэр төрөл	Ажилчдын тоо /өдөр тутам/	Нэгж үнэ	Нийт үнэ	НӨАТ Бусад албан татвар	Бүгд дүн
	300-450				

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Холбоо барих: